



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ

2025 оны 07 сарын 21 өдөр

Дугаар 5/36

Дадал сум

С.Чулууннямыг нүүдлийн гэр цэцэрлэгийн
багшаар түр томилох тухай

Монгол Улсын Боловсролын Ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, Сургуулийн Өмнөх болон Ерөнхий Боловсролын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.5, 64.4, Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Балж багийн Галттай хэсэгт амьдардаг малчид хилчдийн хүүхдүүдийг хамруулах зуны Хувилбарт сургалт, нүүдлийн гэр цэцэрлэгт (Сэмээлийн Чулуунням)-ыг 2025 оны 07 дугаар сарын 21-ний өдрөөс тус бүлгийн багшаар 21 хоногийн хугацаатай томилон ажиллуулсугай.

2. Тус бүлэгт эрүүл аюулгүй орчин бүрдүүлж, хамрагдаж байгаа хүүхэд бүрийн хөгжил, төлөвшил, сурах үйл явцын талаар эцэг эх, асран хамгаалагч нартай хамтран ажиллахыг (С.Чулуунням)-д үүрэг болгосугай.

3. Нүүдлийн гэр цэцэрлэг ажиллуулахтай холбоотой шаардлагатай гэр, бусад тавилга, эд зүйлийн бэлтгэлийг хангаж, хүлээлгэн өгч, хүлээн авч, хариуцаж ажиллахыг нярав (М.Ичинхорлоо)-д даалгасугай.

4. (С.Чулуунням)-ийн цалинг ТҮБД-4 1.559.000 (нэг сая таван зуун тавин есөн мянга) төгрөгөөр тооцож, холбогдох нэмэгдлүүдийг олгохыг нягтлан бодогч (Э.Мөнхмаа)-д зөвшөөрсүгэй.

ЭРХЛЭГЧ Н.ОДГАРАВ

